



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026. 08. 17 № 50

Хууль тогтоомжийн биелэлтийн
талаарх мэдээлэл ирүүлэх тухай

Монгол Улсын 2022-2026 оны тухайн жилийн төсвийн тухай хуулиудаар зээлийн хүүгийн татаас, хөнгөлөлттэй зээл болон үйлдвэрлэл, ажлын байрыг дэмжихтэй холбоотой санхүүжилтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад жил бүр тусган баталж ирсэн бөгөөд Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас, батлан даалт болон бусад эх үүсвэрээр шийдвэрлэхээр тусгажээ.

Энэ хүрээнд Монгол Улсын 2024 оны төсөвт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн татаасанд 223.7 тэрбум төгрөгийн санхүүжилт, 2025 оноос энэ санхүүжилт илүү тодорхой хөтөлбөрүүдэд хуваагдаж, “Хүнсний хувьсгал” хөтөлбөрт 196.1 тэрбум, “Цагаан алт” хөтөлбөрт 113.2 тэрбум, “Атрын IV аян” хөтөлбөрт 98.7 тэрбум, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрт 193.4 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн татаасын санхүүжилт тусгагдсан байна. Мөн Монгол Улсын 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 332.2 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн татаасын санхүүжилт тусгагджээ.

Иймд улсын төсвөөс татаас хэлбэрээр санхүүжүүлж байгаа төсөл, хөтөлбөртэй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлд заасны дагуу дараах асуулгыг тавьж байна:

Нэг. Монгол Улсын 2024-2026 оны төсвөөс зээлийн хүүгийн татаас, хөнгөлөлтөд санхүүжилт олгон хэрэгжүүлсэн дээрх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн талаар;

Хоёр. 2024-2026 онд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хэдэн иргэн, аж ахуйн нэгж, хоршоо хамрагдаж, хэдий хэмжээний зээл олгосон, улсын төсвөөс хэдий хэмжээний хүүгийн татаас авч санхүүжүүлсэн болон төсвийн гүйцэтгэл, үлдэгдэл, татварын орлогын талаар;

Гурав. Тухайн төсөл, хөтөлбөрөөр анх дэвшүүлсэн зорилго, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулахад хэрэгжилт ямар түвшинд хүрсэн, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импорт орлох бүтээгдэхүүн, ажлын байр болон бусад эдийн засаг, нийгмийн үзүүлэлтэд ямар бодит үр дүн, үр нөлөө бий болсон талаар;

2026000146

Дөрөв.Төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудит хийсэн эсэх, илэрсэн зөрчил, эрсдэл, өгсөн зөвлөмж болон тэдгээрийн хэрэгжилтийн талаар.

Тус асуулгын хоёрдугаарт дурдсан төсөл хөтөлбөрт хамрагдсан хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл /нэр, регистрийн дугаар, сонгон шалгаруулалт, зээлийн хэмжээ/-ийг ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Х.ГАНХУЯК

2026000146